

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МӨРДӨН ШАЛГАХ НУУЦ АЖИЛЛАГАА

INFORMATION TRANSPARENCY AND SECRET SURVEILLANCE

Ч.Доржсүрэн
УТИС-ийн тэнхимийн эрхлэгч

Товч агуулга: Монгол Улсын нийтийн мэдээллийн ил тод байдал, иргэдийн мэдээлэл хүлээн авах, хайх эрхийг эдлүүлэх, хуулиар хязгаарлах нөхцөл шаардлага болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарим оролцогчдод хавтаст хэргийн материал танилцуулах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад төрийн нууцыг хадгалах, хамгаалах үндэслэл журам, мөрдөн шалгах нууц ажиллагааны нууцлалыг хангах эрх зүйн зохицуулалтын талаар өгүүлсэн болно.

Түлхүүр үгс: Мэдээлэл хайх, хүлээн авах эрх, хавтаст хэргийн материал, төрийн нууцад хамаарах мэдээлэл, нууц ажиллагааны магадалгаа, нууцлал, аюулгүй байдал

Оршил

Ардчилсан нийгэмд мэдээллийн ил тод байдал нь шударга ёсны суурь, хүний эрх, эрх чөлөөний баталгаа, засаглалын легитим шинжийн илэрхийлэл төдийгүй төрийн эрх мэдэлд тавих хяналт, ард түмний төрдөө итгэх итгэлийн хэмжүүр болдог онцлогтой. НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын¹ 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар, эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайж, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана”² гэжээ.

Мэдээллийн эрин үед цаасан баримт бичиг, хэвлэмэл бүтээлээс гадна харилцаа холбооны сүлжээнээс³ мэдээлэл олж авах, дамжуулах, түгээх боломж нэмэгдэж, мэдээллийн хүртээмж, орон зайг асар хурдтай тэлж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу иргэн нь төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй бөгөөд энэхүү эрхийг хангах нийтлэг болон тусгай харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулдаг. Энэ хүрээнд төрийн байгууллага, албан тушаалтан шийдвэр, үйл ажиллагааныхаа талаар олон нийтэд мэдээлэхийн зэрэгцээ хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах үүрэгтэй. Нууц мэдээллийг цар хүрээ, үнэ цэнэ, ач холбогдлоор нь хэд хэдэн төрөл, зэрэглэлд хуваан эрх бүхий этгээд хуулийн дагуу танилцан ашиглаж, иргэдийн мэдэх эрхэд хязгаарлалт тогтоодог.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж буй оролцогчид хэргийн материалтай танилцах эрхийн дагуу тухайн хэрэгт авагдсан мөрдөн

¹ Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон энэхүү Пактад Монгол Улс 1968.01.05-нд гарын үсэг зурж, 1974.11.18-нд соёрхон баталсан.

² Төрийн мэдээлэл. Тусгай дугаар I боть. УБ, 2004 он. 18 дахь тал

³ Харилцаа холбооны тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1. Харилцаа холбооны сүлжээ нь цахилгаан холбоо, шуудан, радио, телевизийн болон мэдээллийн /интернэт, компьютер зэрэг бусад/ сүлжээнээс бүрдэнэ. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2001 он, №43

шалгах нууц ажиллагааны баримт, мэдээлэлтэй нууцын зэрэглэл харгалзахгүй танилцаж, төрийн нууцад хамаарахаас бусад мэдээллийг хуулбарлан авч болох хуулийн зохицуулалт бий.

Тиймээс мэдээллийн ил тод байдал, эрүүгийн хэргийн оролцогчийн мэдэх эрх, нууц мөрдөн шалгах ажиллагааны нууцлал, тэдгээрийн зохист байдлыг хангах эрх зүйн зохицуулалтыг судалж, сайжруулахад салбарын эрдэмтэн, судлаачдын оролцоо ихээхэн чухал бөгөөд тэдний үндэслэл, судалгаа бүхий шийдлийг хууль тогтоогчид хэлэлцэн шүүж, хууль тогтоомжид тусган хэрэгжүүлбэл зохилтой. Мөрдөн шалгах нууц ажиллагааны нууцлал, аюулгүй байдлыг хамгаалах хууль, удирдлага, зохион байгуулалт, техник хангамж, хяналт шалгалт, сахилга ёс зүйн зэрэг олон арга хэмжээнүүдийг амжилттай хэрэгжүүлэх үндэс нь эрх зүйн орчин бүрдсэн байх явдал юм.

Үндсэн хэсэг

1. Мэдээлэл хайх, хүлээн авах эрх – хуулийн хязгаарлалт: Төрийн байгууллагын мэдэлд буй мэдээллийг олж авах нь хүний язгуур эрх бөгөөд энэхүү эрх нь ил тод байдлыг дээд зэргээр хангаж, үл хамаарах зүйлийн явцуу хүрээнийхээс бусад бүхий л мэдээлэл нь хүртэж болохуйц байх үндэслэл бүрдүүлэх зарчимд тулгуурласан ерөнхий хуулиар дамжуулан үндэсний хэмжээнд хүчин төгөлдөр үйлчлэх ёстой.⁴ Монгол Улсад иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох харилцааг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар⁵ зохицуулдаг. Уг хуульд мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд цуглуулсан, боловсруулсан, ашиглаж байгаа өгөгдлийн бүрдлийг “нийтийн мэдээлэл” гэж тодорхойлоод 6 дугаар зүйлд: 1.Төрийн байгууллага, 2. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоо бүхий хувийн эрх зүйн хуулийн этгээд, 3. Хууль, эсхүл гэрээний дагуу төрийн байгууллагын тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа этгээд, 4. Олон нийтийн радио, телевиз, 5. Улс төрийн намыг нийтийн мэдээллийн хариуцагч байхаар тусгажээ.

Ил тод нээлттэй байхаар заасан мэдээллийг “нээлттэй мэдээлэл”, танилцах, ашиглахад хуулиар хязгаарлалт тогтоосон хүн, хуулийн этгээд болон албаны нууцад хамаарах мэдээллийг “хязгаарлалттай мэдээлэл”, төрийн нууцад хамаарах болон хуульд хаалттай байхаар заасан мэдээллийг “хаалттай мэдээлэл” гэх бөгөөд улсын бүртгэлийн нэгдсэн сан дахь иргэний биеийн давхцахгүй өгөгдлийн /гарын хурууны хээ/ бүртгэл⁶ буюу хүний хувийн нууц /биометрик/ мэдээлэл хаалттай мэдээлэлд хамаарна. Хаалттай мэдээлэл гэхээр огт үзэж, хэрэглэж болдоггүй зүйл биш. Холбогдох хуульд заасан үндэслэл журмын дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтан, мэдээллийн эзэн танилцаж, ашиглаж, ил болгож болно. Жишээлбэл, гүйцэтгэх ажлын мэдээг үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд нийцүүлэн төрийн бодлого боловсруулах, эрх бүхий албан тушаалтнуудад танилцуулах, гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг эрэн сурвалжлах, нотлох баримт цуглуулах, тэдгээрийн эх сурвалжийг олж тогтооход; хүний хурууны хээг иргэний улсын бүртгэл хөтлөх, сонгуулийн үед сонгогчийн бүртгэл хянах, тухайн иргэнийг таних, баталгаажуулахад өөрийнх нь зөвшөөрлөөр ашигладаг.

⁴ Тоби Мендел. Мэдээллийн эрх чөлөө: Эрх зүйн харьцуулсан судалгаа. Парис, 2008. 11-12 дахь тал

⁵ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2022 он, №6

⁶ Улсын бүртгэлийн ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 12 дугаар зүйлийн 12.3.1 дэх заалт. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2018 он, №28

Мэдээлэл хариуцагч нь өөрийн цахим хуудас, төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглан стратеги, чиг үүрэг, үйл ажиллагаа, зохион байгуулалт, хүний нөөц, санхүү, худалдан авах ажиллагаа, ажил үйлчилгээний талаарх болон хуулиар хязгаарласан, хаалттайгаас бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгах үүрэгтэй. Түүнчлэн хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүйгээр, тэдгээрийн эрэлт, хэрэгцээг харгалзан эдийн засаг, бизнесийг дэмжих, судалгаа, шинжилгээний ажлыг хөгжүүлэх, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй, хязгаарлалттай болон хаалттай мэдээллийн хүн, хуулийн этгээд, төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон боловсруулж нээлттэй өгөгдөл болгох хуулийн заалттай.

Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах иргэний эрхийг хэрэгжүүлэхэд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж саад учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэх⁷ нь иргэний мэдээлэл олж авах эрхийг эрүүгийн хуулиар хамгаалж буй хэрэг бөгөөд энэ гэмт хэргийн халдлагын зүйл нь төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй мэдээлэл байна.⁸ Үүнээс тусгайлан хамгаалбал зохих нууц мэдээлэл гэж юу вэ? Яагаад тэдгээр мэдээлэл нийтэд ил тод бус байх болов гэдэг асуултууд үүснэ.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар ...мэдээлэл эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөөг а) бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх, б) үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах шаардлагаар хуулийн хүрээнд хязгаарлаж болох ба Монгол Улсын Үндсэн хуульд ...Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална⁹ хэмээжээ. Төрийн болон албаны нууцын тухай хууль (2016 он), Байгууллагын нууцын тухай хууль (1995 он), Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль (2021 он)-д нууцад хамаарах мэдээллүүдийг тодорхойлон зааж, түүнтэй танилцах, олж авах, боловсруулах, ашиглах, дамжуулах, ил болгох бүрэн эрхийг зөвхөн хуулиар эрх олгогдсон субъектүүд хэрэгжүүлдэг.

Дурдсан хуулиудад: “Төрийн нууц” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг; “Албаны нууц” гэж задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг;¹⁰ “Байгууллагын нууц” гэж хүний эрх, нэр төр, алдар хүнд, тухайн байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох хуулиар нууц гэж тогтоосон мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ.¹¹ Эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, бэлгийн болон хүйсийн чиг

⁷ Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 14.2 дугаар зүйл. Мэдээлэл хайх, хүлээн авахад саад учруулах. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2016 он, №07

⁸ С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй: Тусгай анги (сурах бичиг). УБ, 2020. 99 дэх тал

⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 17 дахь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1992, №1

¹⁰ Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2 дахь заалтууд. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №11

¹¹ Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.2 дахь заалт. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1995 он, №7

баримжаа, илэрхийлэл, бэлгийн харилцааны талаарх хүний эмзэг мэдээлэл нь хувь хүний нууцад хамаарна¹² гэсэн байна. Тэгэхээр төр, байгууллага, хувь хүний эрх, ашиг сонирхлыг хамгаалахаар хуулиар нууцад хамааруулсан мэдээллийг тусгайлан хамгаалбал зохих мэдээлэл гэж ойлгож болно.

Нууцад хамаарах мэдээллийн зэрэглэл, ач холбогдлыг нийтийн мэдээллийн ангилалтай уялдуулан харьцуулбал:

- Төрийн нууц – Хаалттай мэдээлэл
- Албаны нууцад хамаарах мэдээлэл – Хязгаарлалттай мэдээлэл
- Байгууллагын нууцад хамаарах мэдээлэл – Хязгаарлалттай мэдээлэл
- Хувь хүний нууцад хамаарах мэдээлэл – Хязгаарлалттай болон хаалттай мэдээлэл байна.

2. Эрүүгийн хэрэг, материалтай танилцах эрх – нууц хамгаалалт: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид хуулиар тогтоосон үүрэг хүлээхийн хамт тодорхой эрх эдэлдэг. Түүнд шүүгч, прокурор, мөрдөгчийн санал, тогтоол, шийдвэр, шинжээчийн дүгнэлт, хавтаст хэргийн материалтай танилцах эрх багтана. Энэхүү эрхийг хангахын хамт тухайн хэрэгт авагдсан нотлох баримт төрийн нууцад хамаарах, эсхүл тухайн хэрэг бүхэлдээ төрийн нууц мэдээлэл, үйл баримт агуулсан тохиолдолд төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах зорилгоор түүнтэй танилцах, хуулбарлах, хүлээн авахад хориг, хязгаарлалт тогтоох шаардлага үүсдэг. Товхондоо төрийн байгууллага, албан тушаалтан Үндсэн хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөг эдлүүлэхдээ хүний эрх, нэр төр, улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг адил тэнцүү хамгаалах ёстой.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад цуглуулсан мэдээллийг хязгаарлалттай мэдээлэлд хамааруулж, ийм мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрөл шаардахгүйгээр эрх бүхий этгээд хуульд заасан үндэслэл, журмын дагуу танилцах, ашиглах, эсхүл гуравдагч этгээдэд дамжуулж болохоор заасан. Гэтэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бүрдүүлсэн нотлох баримт, хэргийн материал төрийн нууцад хамаарах буюу хаалттай мэдээлэл байх талаарх асуудлыг дараах байдлаар зохицуулжээ.

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.6 дугаар зүйлийн 3 хэсэгт зааснаар төрийн нууцтай холбоотой хэргийг хэрэгсэхгүй болгосон бол яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид тогтоолыг гардуулахгүйгээр танилцуулах бөгөөд саяхан хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр “Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан яллах дүгнэлтийг яллагдагчид бүрэн танилцуулан, төрийн нууцад хамаарах хэсгийг уншигдах боломжгүй байдлаар нууцалж, гардуулан өгнө. Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийг прокурор, оролцогчид бүрэн танилцуулан, төрийн нууцад хамаарах хэсгийг уншигдах боломжгүй байдлаар нууцалж, гардуулан өгнө”¹³ гэсэн зохицуулалтууд шинээр орсон юм.

2. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад прокурор, мөрдөгч хуулиар хамгаалагдсан төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой асуудлаар

¹² Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2022 он, №7

¹³ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 16, 19 дэх хэсэг. 2025 оны 06 сарын 27 өдөр.

хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдээлэл өгөхгүй¹⁴ ч мөрдөгч мөрдөн шалгах бүх ажиллагааг хийж дууссан, хэргийн бодит байдлыг бүрэн нотолж тогтоосон гэж үзвэл яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид хавтаст хэргийн материалтай танилцахыг мэдэгдэж тэдэнд танилцуулах¹⁵ бөгөөд танилцах үндсэн болон сунгах хугацааг хуулиар тогтоосон. Мөн хэргийн оролцогч хүсэлт гаргавал хавтаст хэргийн материалаас төрийн нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах, мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд тусгагдсан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгтэй танилцах боломжтой.

Өмнө нь хаалттай мэдээллийг хуульд заасан үндэслэл журмаар танилцах, ашиглах, ил болгох, хүн, хуулийн этгээд, төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг тодорхойлох боломжгүй нээлттэй өгөгдөл болгох талаар дурдсан. Тэр ёсоор төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан яллах дүгнэлт болон шүүхийн тогтоолын нууц хэсгийг уншигдах боломжгүй байдлаар боловсруулж, гардуулахаар заажээ. Түүнчлэн хуулиар эрх олгогдсон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид төрийн нууцтай танилцаж, хүсвэл хэрэгт авагдсан төрийн нууцад хамаарахаас бусад мэдээлэл (албаны нууц, байгууллагын нууц, хувь хүний нууц)-ийг хувиан авч болдог. Нууцад хамаарах мэдээлэлтэй танилцсан, хуулбарлан авсан тохиолдолд нууцыг задруулахгүй байх баталгааг бичгээр гаргана. Энэ нь төрийн болон албаны нууцыг хамгаалах тухай хууль, төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журамд нийцсэн байна.

Эндээс хууль тогтоогч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний эрх, түүнээс хувь хүний нууцыг хамгаалах, мэдээлэл авах эрх, эрх чөлөө болон төрийн үйл ажиллагааг хуулийн дагуу хэрэгжүүлэх нөхцөл, тэр дундаа төрийн нууцыг хамгаалах явдлыг давхар хангахыг зорьсон нь тод харагдана. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэгжүүлэгч, хууль сахиулагчид үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, бусад хуулийн заалтыг чанд сахих, төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээлэлтэй үндэслэл журмын дагуу танилцсан, хүлээн авсан оролцогч (яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч) нар хуулиар хүлээлгэсэн үүргээ ягштал мөрдөхөөс нууц хамгаалалтын үр дүн шууд шалтгаална.

Сүүлийн үед хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээнд хавтаст хэргийн материал (тэмдэглэл, дүгнэлт, захирамж, тогтоол)-ыг нийтлэх, мөрдөн шалгах ажиллагааны явц байдлаар талаар зөвшөөрөлгүй мэдээлэх үйлдлүүд гарах болсны ард дээрх субъектүүд болон мэдээллийг тарааж буй этгээдүүдийн хариуцлагын асуудал яригдана. Тодорхой нэг эх сурвалжаас мэдээлэл хүлээн авсан сэтгүүлч, сурвалжлагч, инфлүүнсэр гэх мэт мэдээллийг дамжуулагчид нь ихэвчлэн олны анхаарал татсан, дуулиантай хэрэг, үйл явдлын талаар нийтэд түгээж үзэлт, хандалтаа өсгөх зорилго агуулна. Түүнийгээ эрэн сурвалжлах сэтгүүл зүй, мэргэжлийн үйл ажиллагаа, иргэний хувьд үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй холбон тайлбарладаг. Гэхдээ бид мэдээллийн эрх чөлөөг хүндэтгэхийн хамт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой мэдээлэлд хуулийн хүрээнд “цензуртэй” хандах учиртай.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын төлөвлөлт, явц, үр дүнгийн нууцлалыг хангах үүрэгтэй бөгөөд хэргийн материалыг прокурорын мэдэгдэх бололцоотой гэж үзсэн хэмжээгээр, түүний зөвшөөрлөөр

¹⁴ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 8.3 дугаар зүйл /мэдээллээр хангуулах/-ийн 3 дахь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №23

¹⁵ Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан. Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. УБ, 2018. 218 дахь тал

олон нийтэд мэдээлж болдог. Мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг олж мэдсэн хүн, албан үүргийн дагуу олж мэдсэн албан хаагч, ажилтан (прокурорын зөвшөөрөлгүйгээр) мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг задруулсан, шүүгч, прокурор, хууль сахиулагч, өмгөөлөгч, мөрдөн шалгах ажиллагааны нууцыг албаны үүргийн дагуу олж мэдсэн алба хаагч, ажилтан мөрдөн шалгах ажиллагааны нууцалсан баримт, мэдээллийг зориуд задруулж, нууцалсан гэрчийг илчилж хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан¹⁶ бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Хэрэв мөрдөн шалгах ажиллагааны баримт бичиг, мэдээлэл нь төрийн маш нууц, төрийн онц чухал нууцад хамаарч байвал ЭХ-ийн 19.12 дугаар зүйл /Төрийн нууцыг задруулах/-ээр давхар зүйлчилж илүү хүнд ял шийтгэнэ.

3. Мөрдөн шалгах нууц ажиллагааны нууцлал, аюулгүй байдал: Мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад олж мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг задруулахгүй байж, холбогдох баримт бичгийг хамгаалах арга хэмжээг авна. Ялангуяа мөрдөн шалгах нууц ажиллагааны мэдээ, баримтыг зайлшгүй нууцлах шаардлагатай. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.8 дугаар зүйлд мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцохдоо цуглуулж, бэхжүүлэх ажиллагааны арга, хэрэгсэл, эх сурвалж нууц байхаар заасан хэдий ч бүх төрлийн мөрдөн шалгах нууц ажиллагаанууд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга, хэлбэр, гардан гүйцэтгэж буй хүн хүч, техник хэрэгсэл, явуулах байршил, хугацаа, дараалал бүхэлдээ нууц шинж чанартайг мартаж болохгүй. Гэвч “нууц” нэрийн дор дур зоргоор авирлах, хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдахыг хатуу хориглоно. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг биелүүлэхэд прокурор, мөрдөгчийн хуулийн хүрээнд, нууцлалыг бүрэн хангасан мөрдөн шалгах нууц ажиллагаа чухал нөлөөтэй.

Гэмт хэрэг бүрийг нууцаар мөрдөн шалгахгүй, нууц ажиллагааг ердийн ажиллагаагаар илрүүлж, нотлох боломжгүй голдуу бүлэг, зохион байгуулалттай, далд аргаар үйлдэгдсэн хүнд хэргүүд дээр прокурорын зөвшөөрөл, хяналтын дор явуулдаг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйд мөрдөн шалгах нууц ажиллагааны тухай ойлголт, ухагдахуун бий болоод удаагүй учир зохицуулалт, хэрэгжилтэд хүндрэлүүд байсаар байна. Тухайлбал, салбарын судлаачид: “...ямар гэмт хэрэгт, хэдий хугацаанд энэ ажиллагааг явуулах, хугацаа нь дуусахаар хэрхэх талаарх асуудлыг журамласан шийдвэрийг олж мэдэх боломжгүй... , хоёрдугаарт, үндэслэл, журмыг хуульдаа хэрхэн бичих тухай асуудал... , гуравдугаарт, мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад шүүхийн хяналт заавал байх ёстой¹⁷ гэх асуудлуудыг хөнджээ.

Ингээд мөрдөн шалгах нууц ажиллагааны нууцлал, аюулгүй байдалтай холбоотой эрх зүйн зохицуулалтын асуудлыг судлан үзье. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гаргах журам нь хуулийн зарчим, агуулгад нийцсэн байх бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд зааснаас өөрөөр хэрэгжүүлэх хэм хэмжээ тогтоохыг хориглосон байдаг. Хуулийн 29.7 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “...мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулах журам, зааврыг Тагнуулын ерөнхий газрын дарга Улсын ерөнхий прокурортой хамтран батална” гэсэн байна. Хэн батлахыг заасан боловч “нууцаар батална”, эсхүл “нууц журам, зааврыг” гэж бичээгүй тул ил байж таарах нь. Гэвч мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах журам нийтэд төдийлөн нээлттэй бус, мөрдөн ажиллах үүрэгтэй АТГ, ТЕГ, ЦЕГ, УЕПГ-ын холбогдох алба, газар, хэлтсийн хэмжээнд байна. “Мөрдөн шалгах нууц

¹⁶ Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 21.9 дүгээр зүйл. Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2016 он, №07

¹⁷ Нээлттэй нийгэм форум. “Мөрдөн шалгах нууц ажиллагаа” хэлэлцүүлгийн тэмдэглэл. УБ, 2022 оны 12 дугаар сар. 6 дахь тал

ажиллагаа явуулах журам”¹⁸-ыг Улсын ерөнхий прокурор, Тагнуулын ерөнхий газрын даргын 2017 оны 07 сарын 19-ны өдрийн А/84, А/57 дугаар хамтарсан тушаалаар анх баталж, 2018 онд шинэчлэн найруулсан билээ.

Хуульд журмаас гадна “заавар” хэмээн оруулсан нь анхаарал татаж байгаа юм. Одоогоор батлагдсан мөрдөн шалгах нууц ажиллагааны заавар байхгүй. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулах байгууллага, ажилтны үйл ажиллагааны зарчим, эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон энэ хуульд заагаагүй асуудлыг Гүйцэтгэх ажлын тухай хуулиар зохицуулна”¹⁹ гэснээс улбаалан эрх олгогдсон мөрдөгч, гүйцэтгэх ажилтны үйл ажиллагаандаа дагаж мөрддөг гүйцэтгэх ажлын хуульд нийцүүлэн гаргасан гүйцэтгэх ажлын заавар гэж ухаж ойлгоход хүргэнэ. Угаасаа “хавтаст хэрэгт тусгагдаагүй ...гүйцэтгэх ажилтай холбоотой ямар ч баримт мэдээллийг шүүхийн хэлэлцүүлэг, урьдчилсан хэлэлцүүлэг явуулах, хэрэг хянан шийдвэрлэх шүүхэд танилцуулахыг хориглоно”²⁰ гэх хуулийн хэсэг, “Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулахад Гүйцэтгэх ажлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, зааварт заасан арга, ажиллагааг ашиглаж болно”²¹ гэсэн журмын заалтаас мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад гүйцэтгэх ажлын зааварт заасан аргаар цуглуулсан, хавтаст хэрэгт тусгагдсан гүйцэтгэх ажлын мэдээ, мэдээллийг нотлох баримтаар тооцож болох нь илэрхий байна.

Үүнээс үүдэн мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажил хоёрын харилцан хамаарал, хоорондын ялгаа, нууцын зэрэглэл, хэрэгжүүлэх субъект, прокурорын хяналтын талаарх ээдрээтэй олон янзын асуудлууд гарч ирнэ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцохдоо мөрдөгчийн нэр, албан тушаал, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах прокурорын зөвшөөрлийн дугаар, огноо, мөрдөн шалгах нууц ажиллагааны төрөл, тухайн мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад илэрсэн баримтат мэдээлэл, хавсаргасан баримтат мэдээллийн жагсаалт, магадалгааг баталсан прокурорын нэр, албан тушаал²² зэргийг агуулсан нууц ажиллагааны магадалгааг хавтаст хэрэгт тусгана. Нэг үгээр хэлбэл мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг “ил” болгож буй хэлбэр. Гэтэл мөрдөн шалгах нууц ажиллагаа нэрийн дор гүйцэтгэх ажлын аргуудыг хэрэгжүүлдэг бүрэлдэхүүн болон үйл ажиллагааг нь нууцалбал зохих нэгжээр уг ажиллагааг гүйцэтгүүлж үр дүнг мөрдөгчийн магадалгаа нэрээр хэрэгт хавсаргаж байгаа нь Төрийн болон албаны нууцын тухай хууль (13.1.4 дэх хэсэг)-ийг зөрчиж байна²³ гэж салбарын зарим судлаачид шүүмжилсэн нь үндэслэлтэй. Өмнөх “Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах журам”-д мөрдөн шалгах нууц ажиллагааны магадалгаа бичих, үр дүнг ашиглах талаар тусгасан боловч мөрдөн шалгах нууц ажиллагааны нууцлалыг хангах, хавтаст хэрэгт хавсаргах зохицуулалт огт байгаагүй. Шинэ журмаар төрийн нууцад хамаарах хэргийг мөрдөн шалгах, эсхүл уг ажиллагаанд нууц эх сурвалж буюу гүйцэтгэх ажилтан, гүйцэтгэх ажлын туслах хүч оролцсоноос бусад тохиолдолд нууц ажиллагаа явуулах тогтоол, танилцуулга, магадалгаанд “Нууц” тэмдэг дарж, хавсаргасан баримт, сэлтийн хамт нэг хавтас болгон үдэхээр болжээ.

¹⁸ ДХИС-ЦС. Гүйцэтгэх ажлын хууль тогтоомжийн эмхэтгэл. УБ, 2019. 270-280 дахь тал

¹⁹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 16.8 дугаар зүйл /Мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох/-ийн 3 дахь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №23

²⁰ Мөн тэнд. 5 дахь хэсэг

²¹ Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах журмын 1.5 дахь заалт. Улсын ерөнхий прокурор, Тагнуулын ерөнхий газрын даргын хамтарсан 2018 оны 12 сарын 26-ны өдрийн А/116, А/177 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

²² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 26.8 дугаар зүйл /Нууц ажиллагааны магадалгаа/. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №23

²³ Ү.Хосбаяр. Гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал. Эрдэм шинжилгээний өгүүлэл. УТА. “Тусгаар тогтнол” сэтгүүл. 2023 №4 (63), 57 дахь тал

Ийнхүү албаны нууцад хамааруулах нь ахицтай шийдвэр байсан ч төрийн нууцад хамаарах мэдээллийн зэрэглэлийг бууруулж, хэрэгт хавсаргахад хүргэсэн. Төрийн болон албаны нууцын тухай хуулиар гүйцэтгэх ажлын эх сурвалжаас гадна гүйцэтгэх ажилтай холбоотой гүйцэтгэх ажлын шугамаар шалгасан болон шалгаж байгаа хэргийн материал, баримт сэлт, мэдээлэл; бие бүрэлдэхүүнийг нь нууцалбал зохих тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын салбар нэгж, тэдгээрийн барилга байгууламж, байршил, тээврийн хэрэгслийн улсын дугаар, гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн тухай мэдээлэл, эрх бүхий байгууллагын удирдлагаас гүйцэтгэх ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар гаргасан шийдвэр, заавар, журам, бусад баримт бичиг; байгууллагын гүйцэтгэх ажил эрхлэх нэгжийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны тухай мэдээлэл, өөрийн аюулгүй байдлыг хангах ажлын зохион байгуулалт, арга, тактик, хүч, хэрэгсэл, төлөвлөгөөний мэдээлэл болон гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, тайлан, архив, данс, бүртгэл, эд зүйл, тусгай техник хэрэгсэл, нөөц, программ хангамж, нууц түлхүүр бүгд “онц чухал нууц”, “маш нууц” буюу төрийн нууцад хамаарна. Оросын Холбооны Улсын төрийн нууцын тухай хуульд тагнуул, сөрөх тагнуул, шуурхай эрэн сурвалжлах ажиллагааны чиглэлээр: эдгээр төрлийн үйл ажиллагааны хүч, хэрэгсэл, эх сурвалж, арга, төлөвлөгөө, үр дүн, санхүүжилт, тагнуул, мөрдөн байцаах байгууллагатай нууцаар хамтран ажилласан хүн, аж ахуйн нэгжийн мэдээлэл, нууц, кодлогдсон харилцааны систем, шифр, хамгаалалтын хэрэгсэл... гэх мэтийг төрийн нууцад хамааруулсан²⁴ байдаг.

Гол асуудал мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад ашигласан гүйцэтгэх ажлын арга, ажиллагаа, удирдлага болгодог заавар, журам, төлөвлөгөө, тогтоол, илтгэх хуудас, гардан хэрэгжүүлж байгаа гүйцэтгэх байгууллага, ажилтан, тусгай техник хэрэгслийн талаарх мэдээлэл “Нууц ажиллагааны магадлагаа”-нд тусгагдаж байгаад оршино. Шүүгч, прокурор, мөрдөгч хэрэгт авагдсан нотлох баримтыг харьцуулан шинжлэн судлах, бусад нотлох баримттай харьцуулах, шинэ нотлох баримтыг цуглуулах, нотлох баримтын эх сурвалжийг магадлах аргаар нотлох баримтыг шалгаж²⁵ өөрийн дотоод итгэлээр үнэлэх бөгөөд хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь эрүүгийн хэргийн хүрээнд явагдана. Шүүхэд хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтын эх сурвалжийг магадлах, хэргийг тал бүрээс бүрэн бодитой хянан шийдвэрлэх үүднээс мөрдөн шалгах нууц ажиллагаагаар нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэхдээ гүйцэтгэх ажлын ямар хүч, арга, хэрэгслийг ашигласан, хуулийн дагуу явагдсан эсэхийг мэдэх, тодруулах нь зүй ёсны асуудал. Түүнчлэн нууц ажиллагаа чиглэгдсэн хэргийн оролцогч, түүний өмгөөлөгч холбогдох баримт, мэдээлэлтэй танилцах эрхтэй. Гагцхүү эдгээр шаардлагыг хангахын зэрэгцээ мөрдөн шалгах нууц ажиллагаа (гүйцэтгэх ажил)-ны нууцлалыг алдагдуулахгүй байх нь нэн чухал юм.

Мөрдөн шалгах нууц ажиллагааны журам, заавар бүхэлдээ нээлттэй байснаар:

- 1.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид нотлох баримтыг устгах, нуухаас гадна хуурамч эд мөрийн баримт үлдээх, төөрөгдүүлж цаг хожих, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах;
2. Зохион байгуулалттай гэмт бүлэг, гэмт этгээдүүдийн заль мэх, гэмт үйлдлийн арга нарийсаж үйл ажиллагаа нь далд нууц байдалд шилжих, мөрдөн шалгах ажиллагааны эсрэг төлөвлөгөө гаргах;
3. Мөрдөн шалгах байгууллага, мөрдөгч хуулийн хийдэл, зохиомол нөхцөл байдал, үндэслэлгүй гомдол, мэдээлэл, хууль бус дарамт, эсэргүүцэлтэй тулгарч арга ажиллагаа нь суларч хүчгүйдэх;
4. Төрийн болон албаны нууц, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээлэл, баримт бичиг, үйл ажиллагаа задарч, нууц гүйцэтгэх ажилтан, туслах ажилтан, туслагч болон гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэнд аюул, заналхийлэлд өртөх;
5. Гэмт

²⁴ О.А.Городов. Информационное право. М, 2013. С 181

²⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 16.15 дугаар зүйл /Нотлох баримтыг шалгаж үнэлэх/-ийн 3 дахь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №23

хэрэгтэй тэмцэх төрийн бодлого, үйл ажиллагаанд хямрал нүүрлэж, иргэд гэмт хэргийн талаар мэдээлэх, гэрчлэх, хууль сахиулагчидтай хамтран ажиллахаас татгалзах зэрэг эрсдэлтэй.

Тэгвэл хавтаст хэргийн мөрдөн шалгах нууц ажиллагаатай холбоотой магадалгаа, баримт бичиг хязгаарлалттай буюу албаны нууцад хамаарах мэдээлэл байгаа одоогийн тохиолдолд ялладагч болон хүсэлт гаргасан хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч тэдний өмгөөлөгчид төрийн нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах²⁶ эрхийн дагуу авч болно. Хэдийгээр хуулбарлан авсан нотлох баримтыг судлан шинжлэхээс өөр зорилгоор ашиглавал хариуцлага хүлээлгэхээр заасан ч хуулиар төрийн болон албаны нууцыг мэдээлэх, дамжуулах, үзүүлэх, хэвлэн нийтлэх болон бусад арга замаар танилцах эрхгүй этгээдэд хүрэх боломжийг олгож байгаа юм. Авлигатай тэмцэх газар болон цагдаагийн байгууллагын харьяаллын гэмт хэрэгт явуулсан “нууц” тэмдэглэгээтэй мөрдөн шалгах нууц ажиллагааны мэдээлэлд шууд хамааралтай. Учир нь Төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтын тагнуулын байгууллага, төрийн тусгай хамгаалалтын газрын хэмжээнд төрийн нууцад хамааруулсан мэдээлэлд “Мөрдөн шалгах нууц ажиллагаанд хамаарах төлөвлөгөө, тайлан, мөрдөгчийн магадалгаа, нууцалбал зохих баримт бичиг, мэдээлэл”²⁷ багтана. Харин Авлигатай тэмцэх газар, Хууль зүй, дотоод хэрэг, хууль сахиулах салбар, Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын байгууллагын хэмжээнд хамаарах төрийн нууцад мөрдөн шалгах нууц ажиллагааны магадалгаа, төлөвлөгөө, тайлан, баримт бичиг, мэдээлэл гэж байхгүй.

Дүгнэлт, санал

Өнөөдөр манай улсад НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактад тусгалаа олсон хүний (иргэний) мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах болон төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах эрх зүйн үндсийг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулж, төрийн шийдвэр, үйл ажиллагааг олон нийтэд ил тод байлгах, нөгөө талаас төрийн болон албаны нууц, хүний хувийн мэдээллийн нууцыг хадгалж хамгаалах, нээлттэй, хязгаарлалттай, хаалттай мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, тэдгээртэй танилцах, ил болгох харилцааг холбогдох хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудаар зохицуулж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын төлөвлөлт, явц, үр дүнгийн нууцлалыг хангаж, зөвхөн прокурорын зөвшөөрсөн хэмжээнд олон нийтэд мэдээлнэ. Мөрдөн шалгах ажиллагаа дууссаны дараа ялладагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний өмгөөлөгчид хавтаст хэргийн материалтай тогтоосон хугацаанд бүрэн танилцаж, төрийн нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг хуулбарлан авч болох бөгөөд төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан яллах дүгнэлт, шүүхийн тогтоолын нууц хэсгийг уншигдах боломжгүй (нээлттэй өгөгдөл) болгон гардуулан өгөх ажээ. Тусгайлан хамгаалсан нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах иргэний эрхийг хэрэгжүүлэхэд саад учруулсан, мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг прокурорын зөвшөөрөлгүйгээр олон нийтэд мэдээлсэн, нууцалсан гэрч, баримт, мэдээлэл, төрийн нууцыг задруулсан тохиолдолд гэмт хэрэгт тооцож, ял шийтгэхээр хуульчилсан нь эрүүгийн хариуцлагын тогтолцоо хангалттай сайн болохыг илтгэнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оролцогчдын мэдэх эрхийг хангах, төрийн нууцыг хамгаалахад чиглэгдсэн зохицуулалт байгаа боловч тэдгээр нь мөрдөн шалгах

²⁶ Мөн тэнд. 7.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 32.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг

²⁷ Монгол Улсын Төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтын ш/ 44 дэх заалт. Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолын хавсралт

нууц ажиллагааны нууцлалыг алдагдуулахгүй байх тал дээр харилцан уялдаагүй, хуулийн хийдэлтэй байдал ажиглагдлаа. Түүнчлэн Мөрдөн шалгах нууц ажиллагааны журамд нэмж оруулсан нууц ажиллагааны баримт мэдээллийг хавтаст хэрэгт хавсаргах, нууцлахтай холбоотой шинэ заалтад эргэж харах, анхаарал зүйл байна. Өөрөөр хэлбэл мөрдөн шалгах нууц ажиллагааны журам нь ил буюу нээлттэй мэдээлэл, ердийн тохиолдолд нууц ажиллагааны магадалгаа, бичиг баримт нь албаны нууц буюу хязгаарлалттай мэдээлэл, мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад ашиглаж байгаа гүйцэтгэх ажлын арга, ажиллагаа, дагаж мөрдөх заавар, хүн хүч, хэрэгслийн талаарх мэдээлэл нь хаалттай буюу төрийн нууцад хамаарч байна.

Мөрдөн шалгах нууц ажиллагаа нь түүний онцлогоос шалтгаалан нууц байхыг шаардана. Нууц ажиллагааны журам нийтэд нээлттэй байснаар 5 чиглэлийн эрсдэл дагуулах бөгөөд ил журамд төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан нарийвчилсан зохицуулалтуудыг тусгах боломжгүй юм. Цаашид нийтийн мэдээллийн ил тод байдал, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдын эрх, мөрдөх, яллах, цагаатгах, шүүн таслах ажиллагааны зарчим, нотлох баримтыг үнэлэх шалгуур, мөрдөн шалгах нууц ажиллагааны нууцлалын зохист байдлыг хадгалахын тулд мөрдөн шалгах нууц ажиллагааны зарчим, үндэслэл, төрөл, зөвшөөрөл, хугацаа, хүний эрхийг хамгаалах заалтууд, хяналтын тогтолцоо, хүсэлт, гомдол гаргах, хүлээн авах, шийдвэрлэх журам зэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой зааж, нууц арга, тактик, үйл ажиллагааг “маш нууц” зэрэглэлтэй тусгай журмаар зохицуулбал оновчтой.

Холбогдох хууль тогтоомжид оруулах зарим саналыг тодруулбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27.6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт: *...мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулах журмыг Тагнуулын ерөнхий газрын дарга Улсын ерөнхий прокурортой хамтран нууцаар батална.* Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах журамд: *Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах тогтоол, танилцуулга, тайлбар, үр дүн, нууц ажиллагааны магадалгаанд “Маш нууц” тэмдэг дарна.* Төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтын ё/, п/, ю/ хэсгүүдэд: *Мөрдөн шалгах нууц ажиллагаанд хамаарах төлөвлөгөө, тайлан, мөрдөгчийн магадалгаа, нууцалбал зохих баримт бичиг, мэдээлэл /Нууцын зэрэглэл: маш нууц, нууцлах хугацаа (жилээр): 20/ гэж нэмэх, өөрчлөн найруулах зэрэг болно.*

Ашигласан материал

А. Эрх зүйн эх сурвалж

1. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт. 1966 он
2. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он
3. Байгууллагын нууцын тухай хууль. 1995 он
4. Харилцаа холбооны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хууль. 2001 он
5. Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/ 2015 он
6. Төрийн болон албаны нууцын тухай хууль. 2016 он
7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2017 он
8. Улсын бүртгэлийн ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/. 2018 он
9. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/. 2021 он
10. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/. 2022 он
11. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль. 2025 он
12. Монгол Улсын Төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт. Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолын хавсралт
13. Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах журам. УЕП, ТЕГ-ын даргын хамтарсан 2018 оны 12 сарын 26-ны өдрийн А/116, А/177 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Б. Ном, сурах бичиг, эрдэм шинжилгээний бүтээл, тэмдэглэл

1. Тоби Мендел. Мэдээллийн эрх чөлөө: Эрх зүйн харьцуулсан судалгаа. Парис, 2008 он
2. О.А.Городов. Информационное право. М, 2013
3. Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан. Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. УБ, 2018 он
4. ДХИС-ЦС. Гүйцэтгэх ажлын хууль тогтоомжийн эмхэтгэл. УБ, 2019 он
5. С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй: Тусгай анги (сурах бичиг). УБ, 2020 он
6. Нээлттэй нийгэм форум. “Мөрдөн шалгах нууц ажиллагаа” хэлэлцүүлгийн тэмдэглэл. УБ, 2022 он
7. Ү.Хосбаяр. Гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал. Эрдэм шинжилгээний өгүүлэл. УТА. “Тусгаар тогтнол” сэтгүүл. 2023 №4 (63)